

БАТЛАН ХАМГААЛАХЫН САЙД, БОЛОВСРОЛЫН САЙД,
ГЭР БҮЛ, ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЙДЫН
ХАМТАРСАН ТУШААЛ

2026 оны 01 дугаар
сарын 15-ны өдөр

Дугаар А/30-А/12-А/04

Улаанбаатар
хот

“Журам шинэчлэн батлах тухай”


Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь заалт, Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1 дэх заалт, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.4, 11.8 дахь заалт, 23 дугаар зүйлийн 23.1.11 дэх заалт, Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.1.2.1, 4.4.3.7 дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 10 дугаар сарын 22-ны өдрийн 22 дугаар хуралдааны тэмдэглэлээр өгсөн үүргийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Цэргийн алба хаагчийг мэргэжлийн сургалтад хамруулах сургалт зохион байгуулах журам”-ыг хавсралтаар баталсугай.

2. Журмыг батлагдсан өдрөөс эхлэн дагаж мөрдөхийг Боловсролын яамны Дээд, мэргэжлийн боловсролын бодлого зохицуулалтын газар, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Хөдөлмөрийн харилцаа, хөдөлмөр эрхлэлтийн бодлогын газар, Зэвсэгт хүчний Жанжин штаб, Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын болон аймаг, нийслэл, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан байгууллагын дарга, захирал нарт тус тус үүрэг болгосугай.

3. Энэхүү журмыг хэрэгжүүлэхэд удирдлага, зохион байгуулалтаар хангаж, хяналт тавьж ажиллахыг Батлан хамгаалах яамны Төрийн нарийн бичгийн дарга (хошууч генерал Д.Ганхуяг), Боловсролын яамны Төрийн нарийн бичгийн дарга (Х.Батжаргал), Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга (Л.Мөнхзул) нарт даалгасугай.

4. Хамтарсан тушаал батлагдсантай холбогдуулан Батлан хамгаалахын сайд, Боловсролын сайдын хамтарсан 2025 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн “Журам батлах тухай” А/05-А/07 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.





ЦЭРГИЙН АЛБА ХААГЧИЙГ МЭРГЭЖЛИЙН СУРГАЛТАД ХАМРУУЛАХ СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмаар цэргийн алба хаагчийг мэргэжлийн сургалтад хамруулан ур чадвар эзэмшүүлэх сургалтыг зохион байгуулах, сургалтын зардлыг санхүүжүүлэх, хөдөлмөр эрхлэлтийг дэмжихтэй холбогдсон харилцааг зохицуулна.

1.2. Цэргийн алба хаагчийг мэргэжлийн сургалтад хамруулах сургалтыг зохион байгуулахдаа Зэвсэгт хүчний тухай хууль, Боловсролын ерөнхий хууль, Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хууль, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль, "Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-ийн 2.1.2.1 дэх заалт болон холбогдох бусад хууль тогтоомжийг мөрдөнө.

1.3. Журмын үйлчлэлд Зэвсэгт хүчний хугацаат цэргийн алба хаагчийг (цаашид "Цэргийн алба хаагч" гэх) Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагад (цаашид "Сургалтын байгууллага" гэх) мэргэжлийн сургалтад хамруулан ур чадвар эзэмшүүлэх үйл ажиллагааг хамааруулна.

1.4. Мэргэжлийн сургалт гэж Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хуулийн 3.1.6, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 6.3.2-т заасныг ойлгоно.

Хоёр. Сургалтын зохион байгуулалт

2.1. Зэвсэгт хүчний нэгтгэл, анги нь сургалтад хамрагдах цэргийн алба хаагчийг сонгох, бүртгэх, нийслэл болон орон нутаг дахь сургалтын байгууллагатай сургалтын гэрээг байгуулах, мэргэжлийн сургалтад хамруулах арга хэмжээг Зэвсэгт хүчний Жанжин штабын өмнө хариуцаж зохион байгуулна.

2.2. Сургалтад хамрагдах цэргийн алба хаагч дараах баримт бичгийг бүрдүүлж, харьяалах Зэвсэгт хүчний нэгтгэл, ангид бүртгүүлнэ. Үүнд:

- Өргөдөл;
- Цэргийн албанд татагдсан тушаал;
- Иргэний үнэмлэхний хуулбар;
- Цээж зураг 2 хувь;
- Боловсролын баримт бичгийн хуулбар.

2.3. Зэвсэгт хүчний нэгтгэл, ангиуд нь элсэгчдийн мэдээллийг энэхүү журмын хавсралтаар баталсан "Маягт-1"-ийн дагуу Зэвсэгт хүчний Жанжин штабт жил бүрийн 11 дүгээр сарын 15-ны өдрийн дотор хүргүүлнэ.

2.4.Зэвсэгт хүчний Жанжин штаб нь бүс, орон нутгийн бүтээн байгуулалт, ажил олгогчийн хэрэгцээ шаардлага, зах зээлийн эрэлтэд нийцүүлэн мэргэшлийн үндэсний шаталсан бүтцийн мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын I-VI түвшинд чадамжийн нэгжийн хүрээнд ур чадвар эзэмшүүлэхээр цэргийн алба хаагчийг сургах санал, захиалгыг жил бүрийн 11 дүгээр сарын 15-ны өдрийн дотор Хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлж, санхүүжилтийг шийдвэрлүүлнэ.

2.5.Хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь Зэвсэгт хүчний Жанжин штабаас ирүүлсэн санал, захиалгыг Хөдөлмөр эрхлэлтийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд оруулна.

2.6.Зэвсэгт хүчний Жанжин штаб нь энэхүү журмын 2.4-д заасан шийдвэрийг боловсролын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад дараа оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн дотор хүргүүлнэ.

2.7.Боловсролын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь цэргийн алба хаагчдад мэргэжлийн сургалт зохион байгуулах сургалтын байгууллагад арга зүйн зөвлөгөө, дэмжлэг үзүүлж, хэрэгжилтийг ханган ажиллана.

2.8.Сургалтын байгууллага нь аймаг, нийслэл, дүүргийн зэвсэгт хүчний нэгтгэл, анги болон хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан байгууллагатай хамтран цэргийн алба хаагчдад мэргэжлийн сургалтыг зохион байгуулна.

2.9.Мэргэжлийн сургалтын хөтөлбөрийг Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хуулийн 6.15-д заасан журмын дагуу баталгаажуулж, мөрдөнө.

2.10.Мэргэжлийн сургалтын үнэлгээг Боловсролын ерөнхий хуулийн 17.1-т заасан Боловсролын үнэлгээ, арга зүйн байгууллага нь боловсролын бүх түвшний үнэлгээ, элсэлтийн шалгалт зохион байгуулах, хүний мэдлэг, чадвар, чадамжийг үнэлэх, хүлээн зөвшөөрөх, баталгаажуулах, үнэлгээний хөгжлийг хангах чиг үүргийг хэрэгжүүлнэ.

2.11.Үйлдвэрлэлийн дадлагыг ажил олгогчтой хамтран ажлын байранд, эсхүл сургалтын байгууллагын болон цэргийн анги, байгууллагын материаллаг баазыг түшиглэн чадамжийн нэгжийн агуулгын хүрээнд хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлагад нийцүүлэн зохион байгуулж болно.

2.12.Төгсөлтийн үнэлгээ, баримт бичиг олгох үйл ажиллагааг Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хуулийн 8.3-т заасан журмын дагуу зохион байгуулж, сургалтын байгууллага төгсөгчийн мэдээллийг энэхүү журмын хавсралтаар баталсан "Маягт-2"-ын дагуу боловсролын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ.

2.13.Төгсөгчид Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хуулийн 13.1.1-т заасны дагуу "Чадамжийн гэрчилгээ" олгоно.

2.14.Сургалтын байгууллага төгсөгчийн хөдөлмөр эрхлэлтийн судалгаа, тайланг боловсруулж энэхүү журмын хавсралтаар баталсан "Маягт-3"-ын дагуу жил бүрийн 10 дугаар сарын 01-ний өдрийн дотор боловсролын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ.

Гурав. Цэргийн алба хаагчийг мэргэжлийн сургалтад хамруулах сургалтыг зохион байгуулахад талуудын чиг үүрэг

3.1.Батлан хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын чиг үүрэг:

3.1.1.цэрэг халах, татах, нийгэмд эрэлттэй мэргэжлээр ур чадвар эзэмшүүлэх асуудлаар Зэвсэгт хүчний Жанжин штабын бодлого, стратегийн болон сургалтын асуудал хариуцсан нэгжийг бодлогын удирдамжаар хангах;

3.1.2.Зэвсэгт хүчний Жанжин штабаас гаргасан сургалтад хамруулах цэргийн алба хаагчийн тоо, төгсөгчийн хөдөлмөр эрхлэлтийн судалгаа, мэдээлэлд хяналт тавих;

3.1.3.аймаг, нийслэл, дүүргийн Засаг даргын тамгын газрын Цэргийн штабыг тухайн орон нутгийн хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан нэгжтэй хамтран мэргэжлийн сургалтад хамрагдаж цэргийн албанаас бэлтгэлээр халагдсан иргэдийн мэдээллийг мэдээллийн санд оруулах, ажлын байраар хангахад дэмжлэг үзүүлэх чиглэлээр үүрэгжүүлэх.

3.2.Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын чиг үүрэг:

3.2.1.мэргэжлийн сургалтыг зохион байгуулахад Боловсролын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагыг бодлогын удирдамжаар хангах;

3.2.2.Боловсролын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагаас баталгаажуулан ирүүлсэн энэхүү журмын 2.14-т заасан төгсөгчийн хөдөлмөр эрхлэлтийн судалгааг хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад жил бүрийн 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор хүргүүлэх.

3.3.Хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын чиг үүрэг:

3.3.1.зэвсэгт хүчний нэгтгэл, анги, байгууллагаас бэлтгэлээр халагдсан иргэдийг хөдөлмөрт бэлтгэх, хөдөлмөр эрхлэлтийн сургалт зохион байгуулах, ажилд зуучлах, хөдөлмөрийн зах зээлд оролцогчийг бүртгэх, мэдээллээр хангах, зөвлөгөө өгөх, ажил мэргэжлийн чиг баримжаа олгох талаар аймаг, нийслэл, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан байгууллагыг үүрэг, чиглэл, бодлогын удирдамжаар хангах;

3.3.2.цэргийн алба хаагчийг мэргэжлийн сургалтад хамруулах сургалтын зардлыг Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 11.4-т заасны дагуу шийдвэрлэх.

3.4.Зэвсэгт хүчний Жанжин штабын чиг үүрэг:

3.4.1.цэргийн алба хаагчийг суралцах хугацаанд нь сургалтын байгууллага, Зэвсэгт хүчний анги, байгууллага хооронд тээвэрлэх, хооллох болон хүнсний бүтээгдэхүүний чанар, эрүүл ахуйн асуудлыг хариуцах;

3.4.2.мэргэжлийн сургалтад хамрагдаж цэргийн албанаас бэлтгэлээр халагдсан иргэдийн бүртгэл, мэдээллийг нэгтгэж аймаг, нийслэл, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан байгууллагад жил бүрийн 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор хүргүүлэх;

3.4.3.цэрэг татлагын товчоонд захиалгын хуудсанд тусгагдсан мэргэжлийн чиглэлээр цэргийн албанд татагдсан иргэдийг ангиудад хуваарилан ажиллах алба хаагчийг тушаалаар томилон ажиллуулах.

3.5.Аймаг, нийслэл, дүүргийн Засаг даргын тамгын газрын Цэргийн штабын чиг үүрэг:

3.5.1.аймаг, нийслэл, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан байгууллагаас тухайн орон нутаг дахь ажлын сул байрны мэдээллийг авч энэхүү журмын хавсралтаар батлагдсан Маягт-4-ийн дагуу Цэрэг татлагын товчоонд хүргүүлэх;

3.5.2.мэргэжлийн сургалтад хамрагдаж цэргийн албанаас бэлтгэлээр халагдсан иргэдийн мэдээллийг тухайн аймаг, нийслэл, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан байгууллагад хүргүүлж, ажлын байранд зуучлахад дэмжлэг үзүүлэх;

3.5.3.аймаг, нийслэл, дүүргийн боловсролын асуудал хариуцсан байгууллагатай хамтран ажиллах, тухайн байгууллагаас эзэмшсэн мэргэжлээрээ хөдөлмөр эрхэлж буй иргэдийн судалгааг авч Батлан хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагыг улирал тутам мэдээллээр хангах.

3.6.Боловсролын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын чиг үүрэг:

3.6.1.сургалтын байгууллагад арга зүйн зөвлөгөө, дэмжлэг үзүүлэн, мэргэжлийн сургалтын хөтөлбөрийн дүгнэлтийг баталгаажуулж, төгсөгчийн баримт бичгийг олгон, холбогдох статистик мэдээллийг хөтөлж, нэгтгэх, тайлагнах;

3.6.2.Энэхүү журмын 2.14-т заасан төгсөгчийн хөдөлмөр эрхлэлтийн судалгаа, тайланг хянаж баталгаажуулан жил бүрийн 11 дүгээр сарын 01-ний өдрийн дотор Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх.

3.7.Аймаг, нийслэл, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан байгууллагын чиг үүрэг:

3.7.1.тухайн орон нутаг дахь ажлын сул байрны мэдээллийг аймаг, нийслэл, дүүргийн Засаг даргын тамгын газрын Цэргийн штабт жил бүрийн 09 дүгээр сарын 25-ны өдрийн дотор хүргүүлэх;

3.7.2.мэргэжлийн сургалтад хамрагдаж цэргийн албанаас бэлтгэлээр халагдсан иргэдийн мэдээллийг хөдөлмөр эрхлэлтийн нэгдсэн бүртгэл, мэдээллийн санд оруулж, хөдөлмөрийн биржид бүртгүүлэн, ажилд зуучлах, ажлын байртай болоход дэмжлэг үзүүлэх;

Дөрөв.Сургалтын санхүүжилт

4.1.Сургалтын санхүүжилт дараах эх үүсвэрээс бүрдэнэ:

4.1.1.Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан;

4.1.2.бусад эх үүсвэр.

Тав.Хэрэгжилтийг тайлагнах, хяналт тавих

5.1.Сургалтын байгууллага нь элсэлт, төгсөлтийн мэдээ, төгсөгчийн хөдөлмөр эрхлэлтийн судалгаа, сургалтын тайланг Боловсролын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага болон Хөдөлмөрийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад зохих журмын дагуу хугацаанд нь хүргүүлнэ.

5.2.Журмын хэрэгжилтийн явц, үр дүнд Боловсролын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага болон Хөдөлмөрийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, Зэвсэгт хүчний Жанжин штаб хяналт тавьж ажиллана.

Зургаа.Бусад

6.1.Энэхүү журмыг 2025-2026 оны хичээлийн жилээс эхлэн 4 жилийн хугацаанд үе шаттайгаар хэрэгжүүлнэ.

6.2.Журмын хэрэгжилттэй холбоотой нэмэлт өөрчлөлт оруулах асуудлыг талууд харилцан тохиролцож шийдвэрлэнэ.

---o0o---

Мэргэжлийн сургалтад хамрагдах цэргийн алба хаагчийн мэдээлэл
..... сургалтын байгууллага

20 оны дугаар сарын -ны өдөр

Д/д	Овог	Нэр	Регистрийн дугаар	Эзэмшүүлэх чадамжийн нэгжийн нэр	Үндсэн харьяалал	Харьяалагдах цэргийн нэгтгэл, анги, байгууллага
1						
2						
3						
...						

Судалгаа гаргасан:

.....
(албан тушаал)

.....
(гарын үсэг)

.....
(овог, нэр)

Хянасан:

.....
(албан тушаал)

.....
(гарын үсэг)

.....
(овог, нэр)

Мэргэжлийн сургалт зохион байгуулах ажлын хүрээнд сургалтын
байгууллага /доогуур зурах/-ийн сургалтад хамрагдсан цэргийн алба хаагчийн
төгсөлтийн талаарх мэдээлэл

20.... оны дугаар сарын-ны өдөр

Д/д	Овог	Нэр	Регистрийн дугаар	Эзэмшүүлэх чадамжийн нэгжийн нэр	Үндсэн харьяалал	Олгох бичиг баримт
1						
2						
3						
...						

Судалгаа гаргасан:

Сургалтын байгууллагын

.....

.....
(гарын үсэг)

.....
(овог, нэр)

Хянасан:

Сургалтын байгууллагын

захирал

.....
(гарын үсэг)

.....
(овог, нэр)

Мэргэжлийн сургалтад хамрагдсан цэргийн алба хаагчдын
хөдөлмөр эрхлэлтийн судалгаа

20 ... оны ... дугаар сарын ... -ны өдөр

Д/д	Овог	Нэр	Регистрийн дугаар	Эзэмшүүлэх чадамжийн нэгжийн нэр	Ажлын байрны мэдээлэл	Алба хаасан цэргийн нэгтгэл, анги, байгууллага
1						
2						
3						
...						

Судалгаа гаргасан:

.....
(албан тушаал)

.....
(гарын үсэг)

.....
(овог, нэр)

Хянасан:

.....
(албан тушаал)

.....
(гарын үсэг)

.....
(овог, нэр)

..... аймгаас (..... дүүргээс) 20... оны II ээлжээр хугацаат цэргийн албанд татагдсан иргэдээс мэргэжлийн сургалтад хамруулах захиалгын хуудас

Д/д	Овог, нэр	Шаардлагатай ажлын байр	Эзэмшүүлэх чадамжийн нэгжийн нэр	Тайлбар
..... сум (..... хороо)				
1.				
2.				
..... сум (..... хороо)				
..... сум (..... хороо)				

Захиалгын хуудсыг хүлээлгэн өгсөн:

..... аймгийн /эсвэл дүүргийн/ ЗДТГ-ын дэргэдэх

Цэргийн штабын дарга

/...../ /...../ /...../

/цол/

/гарын үсэг/

/гарын үсгийн тайлал/

20... оны ... сарын ... -ны өдөр

Захиалгын хуудсыг хүлээн авсан:

Цэрэг татлагын товчооны хуваарилалт

хариуцсан офицер

/...../ /...../ /...../

/цол/

/гарын үсэг/

/гарын үсгийн тайлал/

20... оны ... сарын ... -ны өдөр